

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР  
СПОРТЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЙЧИН  
ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО



ГАНЦААРЧИЛСАН  
БАГУЙН  
ХОЛИМОГ ХОС  
ЧӨЛӨӨТ

**ПҮМСЭ**

БҮХ НАС: А, В, С АНГИЛАЛ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР

# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭН 2024

# 2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ



Mongolia Taekwondo channel



www.facebook.com/MongolTaekwondo



# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ 2024 ОНЫ ТАЕКВОНДО ПҮМСЭ МОНГОЛ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

### ЗОРИЛГО:

- Олимпын төрөлт таеквондогийн спортыг Өмнөговь аймагт сурталчлах,
- Таеквондогийн спортын олон төрлийг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах.
- 2024 оны Таеквондо пүмсэ төрлийн Ази тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөх тамирчдыг сонгон шалгаруулах.

### ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	“Монголын Таеквондогийн Холбоо” ТББ Өмнөговь Аймгийн Засаг Даргын Тамгын газар Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар Өмнөговь аймгийн Дайчин таеквондогийн холбоо
Холбоо барих утас	7015-5500, 8619-0073
Имэйл	mongoliatekwondo@gmail.com
Нийгмийн сүлжээ	<a href="https://www.facebook.com/MongolTaekwondo">https://www.facebook.com/MongolTaekwondo</a> ,
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Спортын төв Ордон

### ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
01 сарын 02-15	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
	Буудал захиалга	Дайчин таеквондогийн холбоо 9104-5356
01 сарын 22	Техникийн зөвлөгөөн	Өмнөговь аймаг, Даланзадгад хот
01 сарын 23-25	Тэмцээн	Өмнөговь аймаг, Даланзадгад хот

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.

# 2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ

## ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

### 1) ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна, зөвхөн тэр бүсээ бүсэлж тухайн бүсний ангилалдаа өрсөлдөнө.
- Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- Бүртгэлийн хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй!
- УАШТ-д Монголын таеквондогийн холбоотой гэрээтэй, албан ёсны гишүүн байгууллага түүний тамирчид оролцоно.
- УАШТ-д оролцох байгууллага нь холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.
- Тамирчин нь Монголын таеквондогийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.
- А ангилалд өрсөлдөх тамирчин нь пүмсэ тобог өмсөх шаардлагатай.

Монгол улсад хэрэглэгдэх таеквондогийн өмсгөлийн стандарт



### ПҮМСЭ

Пүмсэ буюу тоот дасгалын тамирчид Ү төрлийн задгай энгэртэй өмсгөл өмсөнө. 15 хүртэлх насны тамирчид хүйснээс хамааран улаан болон хөх өнгийн өмд, улаан, хар судал бүхий энгэрийн эмжээр бүхий дээд өмсгөл өмсөнө. Өндөр дан (Хар бүс 7-р дан болон түүнээс дээш) болон ахмад настай мастерууд ердийн цагаан өнгөний оронд алтан шар өнгийн өмсгөл өмсөх эрхтэй байдаг байна.



**ГҮП, ПҮҮМ ЗЭРЭГ**  
 15 хүртэлх насны тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.  
 Өмдний тухайд:  
 Эрэгтэй: Хөх өнгө  
 Эмэгтэй: Улаан өнгө



**ДАН ЗЭРЭГ**  
 16 ба түүнээс дээш настай хар бүстэй тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.  
 Өмдний тухайд:  
 Эрэгтэй: Хар өнгө  
 Эмэгтэй: Саарал өнгө




**МАСТЕР**  
 Хар бүс 7-р дан болон түүнээс дээш дантай мастерууд. Мөн түүнчлэн ахмад настай мастер тамирчид Алтан шар өнгийн өмсгөл өмсөнө.

# 2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ





ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕНИЙ ТАМИР  
СПОРТЫН ГАЗАР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЧИН  
ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО

# ТАЕКВОНДО ЛҮҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

- В, С ангилалд өрсөлдөх тамирчин ердийн тулааны тобог өмсөн оролцож болох хэдий ч Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана.
- Тэмцээний өмсгөлийн стандарт

## УРД ТАЛ




## АР ТАЛ



2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ



# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

## 2) АНГИЛАЛ

Үндсэн пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Эрэгтэй баг (3 эрэгтэй)
Эмэгтэй баг (3 эмэгтэй)
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)

Чөлөөт пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)
Холимог баг (5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба эрэгтэй, эмэгтэй тамирчдын тоо тус бүр хамгийн багадаа 2, 2 байх ёстой)

Холимог хос, багийн ангилалд зөвхөн өөрийн бүсний ангиллын тамирчин, тамирчидтай хамтарна. /Жишээлбэл: С ангиллын тамирчин А ангиллын тамирчинтай нэг баг эсвэл хос болж болохгүй/

## 3) ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУГАЦАА

Үндсэн пүмсэ: 90 секунд хүртэл

Чөлөөт пүмсэ: 90-100 секундын хооронд

Завсарлага: Эхний пүмсэ болон хоёр дахь пүмсэ хоорондын зай хамгийн багадаа 30 секунд

2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ

# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

## 4) ОРОЛЦОГЧ

- Тэмцээнд оролцогчид хүйс, насаар хязгаарлагдахгүй бол дээд тал нь хоёр ангилалд өрсөлдөх боломжтой.
- 2023 оны таеквондо пүмсэ УАШТ-д медаль хүртсэн тамирчид ангилал дээшилж оролцох шаардлагатай. Жишээлбэл: 2023 оны УАШТ-д С ангилалд оролцон медаль хүртсэн тамирчин нь 2024 оны УАШТ-д В буюу түүнээс дээш ангилалд орох боломжтой.
- Насны хувьд:
  - Бага нас: 8-9 нас
  - Бага нас: 10-11 нас
  - Өсвөр үе: 12-14 нас
  - Залуучууд : 15-17 нас
  - Насанд хүрэгч 30 хүртэлх (17-30 нас)
  - Насанд хүрэгч 30-аас дээш насны ангилалд тэмцээн явагдана.
  - Насыг сараар бус жилээр тооцно. Жишээлбэл: Залуучуудын ангилалд өрсөлдөх тамирчин нь 2007.1.1-2009.12.31 хооронд төрсөн байна.
- Бүсний ангилал:
  - А ангилалд хар бүс, куккивоны дантай тамирчид
  - В ангилалд хөх, улаан бүстэй тамирчид
  - С ангилалд шар, ногоон бүстэй тамирчид тус тус оролцох эрхтэй.
  - Чөлөөт пүмсэ төрөлд насны ангилал байх боловч бүсний ангилалгүй өрсөлдөнө.
  - Насанд хүрэгчдийн элит ангилалд зөвхөн хар бүстэй тамирчид өрсөлдөнө
  - Насанд хүрэгчдийн сонирхогчдын ангилалд бүсний ангилалгүй өрсөлдөнө

# 2024.01.23-25

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ



# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

## 5) ГҮЙЦЭТГЭХ ПҮМСЭ

Үндсэн пүмсэ: Ганцаарчилсан (эрэгтэй, эмэгтэй), Холимог хос, баг

Нас	Ангилал	Урьдчилсан шат	Шигшээ шат
<b>Бага нас</b>	А ангилал	Таекүк 6 жан	Таекүк 7, 8 жан
	В ангилал	Таекүк 3 жан	Таекүк 4, 5 жан
<b>Өсвөр үе</b>	С ангилал	Таекүк 1 жан	Таекүк 2, 3 жан
<b>Залуучууд</b>	А ангилал	Таекүк 7 жан	Таекүк 8 жан, Корёо
	В ангилал	Таекүк 5 жан	Таекүк 6, 7 жан
	С ангилал	Таекүк 2 жан	Таекүк 3, 4 жан
<b>Насанд хүрэгч /Элит ангилал/ 30 нас хүртэлх 30-аас дээш</b>	А ангилал	Корёо	Кимган, Тебек
<b>Насанд хүрэгч /сонирхогч/</b>	Бүсний ангилалгүй	Таекүк 1 жан	Таекүк 2, 3 жан

### Чөлөөт пүмсэ:

Тамирчид таеквондогийн техник дээр тулгуурлан хөгжим, бүжиг дэглэлт бүхий чөлөөт пүмсэ гүйцэтгэнэ. Гүйцэтгэх техникүүд нь таеквондогийн хүрээнд байх ёстой. (сууултууд: Дидкүби соги, Хақдари соги, Боем Соги, үсэрч: ёбчаги, степ, 180, 360 градус эргэлттэй өшиглөлт)

Өөрсдийн зохиосон пүмсэг 90-100 секундын хугацаанд хөгжмийн аянд хийж гүйцэтгэнэ. Заасан хугацаанаас бага хугацаанд эсвэл хугацаа хэтэрвэл оноо хасагдана. Заавал хийх техникүүдийг оруулсан байх бөгөөд уран сэтгэмж, хөдөлгөөний эвсэл, аяны зохицол, дэвжээ эзэмшилт болон өндөр градустай техникийг харж дүгнэнэ.

**2024.01.23-25**

ӨМНӨГОВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ



# ТАЕКВОНДО ПҮМСЭ

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

## 6) ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ

Нэг төрөлд оролцох тамирчны дэвжээний төлбөр:

- Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн тамирчид 50.000 (тавин мянга) төгрөг,
- Хөдөө орон нутгийн тамирчид:
  - Даланзадгад хотоос 1000 км дотогш 30.000 (гучин мянган) төгрөг
  - Даланзадгад хотоос 1000 км гадагш Үнэ төлбөргүй
- Хоёр төрөлд оролцох тамирчны хувьд дэвжээний төлбөр дээр 10.000 (арван мянга)-н төгрөг нэмэгдэнэ.

### Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

## 7) ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явуулж, 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна. /Спортын цол, зэргийн болзолд А ангиллыг тооцно. В, С ангилал спортын цол, зэргийн болзолд хамаарахгүй болно./

- Багийн дүнгээр: А, В, С ангилалд тус бүр 1, 2, 3-р байр эзэлсэн багуудыг цом, медаль, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.
- Насанд хүрэгчдийн сонирхогчийн ангилал болон бүх насны чөлөөт пүмсэ төрөлд медаль хүртсэн тамирчдын медаль багийн дүнд тооцогдохгүй.
- Шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин, дасгалжуулагч, шүүгчийг тодруулан шагнаж урамшуулна.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО –

# 2024.01.23-25

ӨМНӨГӨВЬ АЙМАГ - ДАЛАНЗАДГАД ХОТ